

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
12 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-9
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-118
	1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг	10-73
	2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.11.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	73-75
	3. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.11.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	75-78
	4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 09 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан/	79-80
	5. “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл / эцсийн хэлэлцүүлэг /	80-81
	6. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Зам тээврийн салбарт хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлын явцын талаар/	81-105
	7. “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл / эцсийн хэлэлцүүлэг / үргэлжлэл	105-113
	8. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг /	113-118

ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Долоо.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Монгол Улсын гавьяат хуульч

Н.Лувсанжав, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, профессор, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, мөн сургуулийн багш Д.Ганзориг, нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Хосбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар “Үндсэн хууль” танхимаас танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д заасны дагуу хуулийн төслийг Байнгын хороонд буцаах санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав. Танхим тус бүрээс ирсэн санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 13

Бүгд: 56

76.8 хувийн саналаар дэмжигдсэн тул хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд буцаав.

Уг асуудлыг 16 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./16:42/

2.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./16:42/

3.Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн

найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./16:42/

4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./16:42/

5.“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:42/

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг “Их хуралдай” танхимд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт Б.Баярсайхан, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн референт Б.Туул, шинжээч М.Номиндулам, Э.Сувд-Эрдэнэ, “Их эзэн Чингис хаан” танхимд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан нарийн бичгийн дарга Г.Нямсүрэн, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн Хуралдааны тэмдэглэл хөтлөх албаны шинжээч П.Мядагмаа, “Жанжин Д.Сүхбаатар” танхимд Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны референт Р.Дэлгэрмаа, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн Хуралдааны тэмдэглэл хөтлөх албаны шинжээч Д.Уянга, “Үндсэн хууль” танхимд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн шинжилгээний хэлтсийн Кодификаци, редакцийн албаны референт Б.Хангай, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн Хуралдааны тэмдэглэл хөтлөх албаны шинжээч Д.Цэндсүрэн, “Их засаг” танхимд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн Хуралдааны тэмдэглэл хөтлөх албаны шинжээч Ц.Алтан-Од нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Хууль, эрх зүйн газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, мөн хэлтсийн Программ хангамжийн албаны ахлах референт Ч.Тунгалаг, референт С.Мөнхтөр, шинжээч Б.Эрдэнэбаяр нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 40 минут үргэлжилж, 74 гишүүнээс 56 гишүүн хүрэлцэн ирж, 75.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар Үндсэн хуулийн танхимаас танилцуулна аа.

Ж.Сүхбаатар: За баярлалаа. Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Нямбаатар, Ц.Мөнх-Оргил, Ё.Баатарбилэг, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Н.Амарзаяа, Ж.Батзандан, Д.Ганболд нар 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2020 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 03 тоот захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатараар ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Г.Ганболд, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр төслийг чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар дээрх хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, ажлын хэсгийн дэмжсэн 56 зарчмын зөрүүтэй болон найруулгын 4 багц саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцүүлэхээр чуулганы нэгдсэн хуралдаанд оруулсан.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг уг асуудлаар 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдөр ажлын 5 өдрийн, 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр ажлын 3 өдрийн завсарлагыг тус тус чуулганы нэгдсэн хуралдаанаас авсан бөгөөд Улсын Их Хурлын 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль явагдсантай холбогдуулан зарим зарчмын зөрүүтэй саналыг эргэн харах, сайжруулах нөхцөл үүссэн гэж үзэн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн тул хуулийн төслийг Байнгын хороонд буцаасан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин хийлээ.

Төслийг чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдөр бэлдсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн 53, Байнгын хорооны дэмжээгүй 6, найруулгын 1 багц санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн Байнгын хорооны дэмжсэн 6, найруулгын 1 саналаас зайлшгүй сайжруулах шаардлагатай болон үүссэн нөхцөл байдлыг харгалзсан 22 зарчмын зөрүүтэй, 1 багц, найруулгын санал болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн талаарх 1 зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулж Байнгын хорооны хуралдаанд оруулсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд ажлын хэсэг дахин бэлдсэн 24 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж, бусад саналыг 2020 оны 8 дугаар сарын 19-ний Байнгын хорооны хуралдаан дэмжсэн томьёоллоор чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах талаар горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн гучин есдүгээр зүйлд заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийг нь дэмжсэн зарчмын зөрүүтэй болон найруулгын багц саналын томьёоллоор санал хураалт явууллаа.

Ажлын хэсгийн дэмжсэн хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг аймаг, нийслэл, сумын тодорхойлолтыг нэгжийг өөрчлөх асуудлыг санаачлахдаа өмнө нь иргэдэд үзүүлж байсан үйлчилгээг дордуулахгүй байх зарчим баримтлахыг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн асуудлыг, орон нутгийн чиг үүргийг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн нэгжийн хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавхыг харгалзан хөрөнгө хуваарилах, хуульд заасан үндэслэл, журмын дагуу концесс болон үнэт цаас гаргах асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал шийдвэрлэх, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн дараах иргэдийн нийтийн хурлын хуралдааныг сум, дүүргийн засаг дарга шинээр томилогдсоны дараа зохион байгуулахаар, 2024 оноос улс төрийн нам, эвсэл, сум, иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй асуудлыг, мөн ээлжит сонгуулийн дүнг өргөн мэдүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн шатны сонгуулийн хороо, иргэдийн төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдааныг зарлан хуралдуулах, анхдугаар хуралдааны хуралдаанд хүрэлцэн ирсэн насаар хамгийн ахмад сонгогдсон төлөөлөгч даргалах зэрэг 23 зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Тус Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засаг захиргаа, нутгийн дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: За Сүхбаатар даргад баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя аа. Дондовын Ганзориг, Цэдэвийн Даваасүрэн, Равдангийн Хатанбаатар, Алтангэрэлийн Бямбажаргал, Намсрайжавын Лувсанжав, Сумъяагийн Сүхбаатар нарын Хууль зүйн ухааны доктор, гавьяат хуульч, Улсын Их Хурал, Бага Хурлын гишүүн асан, цэцийн гишүүн, Хууль зүйн сургуулийн багш байсан ийм хүмүүс байна аа.

За эрхэм гишүүд ээ, Нутаг нутгийн удирдлагын дэд хорооноос санал гаргасан. Ирэх 7 хоногт шинээр сонгогдсон орон нутгийн удирдлагуудтай цахим хурал зөвлөгөө хийж, энэ хуулийн төслийг хэлэлцүүлэх саналуудыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нартай цахим уулзалт хийх үеэр тавьсан ийм цахим хэлэлцүүлэг зохион байгуулъя гэж.

2 дугаарт нь манай бас нийслэлээс сонгогдсон зарим гишүүд орон нутгийн хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль дээр ажиллаж байгаа хэсгүүд бас уялдуулах, эргэж харах шаардлага байна аа гэсэн санал тавьсан.

3 дугаарт нь өнөөдөр техникийн шалтгаанаар энэ 78 санал хураалт явуулахад бас май парламент санал хураалтын техникийн сааталтай байна.

Тэгэхээр энэ хуулийн төслийг дараагийн 7 хоногт заавал хэлэлцэх ёстой. Тэгээд тэр хүртэл бас энэ хэлэлцүүлгүүдийг явуулъя. Одоо хойшлуулах ийм горимын саналуудыг гаргасан энүүгээр санал хураалт явуулна аа.

За ер нь Байнгын хороон дээр гүйцээн боловсруулах чиглэлүүд яригдсан. Тэгэхээр гүйцээн боловсруулах асуудал нэгтэй хамт явах учраас өнөөдөр нэгдүгээрт нь Үндсэн хуулийн тавин наймдугаар зүйлийн нэгдүгээр заалттай нийцүүлж энэ концепцын өөрчлөлтийг тодотгох шаардлагатай байна аа.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн гэж тавин долоогийн нэг тодотгох шаардлагатай. Энийг Чимэд гуай Үндсэн хуулийн үзэл баримтлал номдоо, энэ бол субъект юм аа гэж тодотгон залруулсан гадаад үг хэрэглэхгүй гэсэн учраас тодотгон залруулсан гэж.

Дэлхийн бүх хот, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бол эдийн засгийн агуулга, татвар, өмчийн харилцаан дээр тулгуурлаж байгуулагдсан байдаг. Манай Дархан, Эрдэнэт хот гэхэд Эрдэнэт үйлдвэр дээр, Дарханы аж үйлдвэрийн цогцолбор дээр түшиглэж энэ хот нэгж, түүний удирдлага байгуулагдсан. Хуучин социализмын үед ч гэсэн тэр сум, нэгдэл гэж нийгэм, эдийн засгийн цогцолбор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэгж хэлбэрээр ажиллаж байсан сум, нэгдэл гэж нийгэм, эдийн засгийн цогцолбор.

Энэ 1992 онд энэ хууль батлагдах үед бол сум, нэгдэл, нэгдэл тараагүй байсан. За дараа нь нэгдлүүд хувьчлагдсан энэ сум нийгэм эдийн засгийн цогцолбор байх агуулга алдагдсанаас өнөөдөр бүх засаг захиргааны нэгжүүд төвлөрсөн төсвөөс хараат, төсвийн хуваарилалтаар амьдардаг, хамаг орлого дээшээ төвлөрдөг ийм нийгэм эдийн засгийн цогцолбор байх энэ тавин наймын нэгдүгээр заалт алдагдсан. Энийг тодотгох шаардлагатай.

2 дугаарт, энийг тодотгох зорилгоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх татварын хувь хэмжээг тогтоох хэрэгтэй гэж заасан. Энэ бол нийгэм, эдийн засгийн нэгж корпоративный нэгж байх заалтыг тодотгосон заалт юм. Ингэснээрээ бол өмчийн удирдлагыг л хэрэгжүүлснээрээ, өмчийн харьяалал тогтоно, иргэний эрх зүйн хувьд ч тэр. Маргаантай байгаа нэг асуудал бол төрийн ба орон нутгийн өмч. Үндсэн хуульд төрийн өмч гэдэг л өмчийн нэг хэлбэр бий. Төрийн ба орон нутгийн өмч гэж хоёр салахаараа дунд нь хөрөнгө баялаг завшигдах маш их бололцоог нээж байна аа.

Нөгөө талдаа орон нутгийн удирдлагад өмчийн удирдлагаа хэрэгжүүлэх эрх өгөгддөггүй ээ. Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нэг машинаа зарж борлуулах хүртэл Засгийн газраар хурлаар оруулж шийдүүлдэг. Энэ бол өмчийн орон нутгийн өмч гэхээд өмчийн удирдлагын эрхээ хэрэгжүүлэхгүй байгаа нь өөрөө ди юрий өмч эзэмшигч байх эрхээ хадгалж чадахгүй байгаа болж байгаа юм. Энэ бол туйлын эрхийг хэлж байгаа, харилцаанд орж байгаа орон нутгийн өмчийн эрх гэдэг болбол туйлын эрхтэй байх асуудал байдаг. Энэ асуудал болбол хуулиар нэг мөр шийдэгдэх ёстой байгаа юм. Тэгэхээр муур хар юм уу, шар байх нь гол биш. Өөрөөр хэлбэл төрийн өмч, орон нутгийн өмч гэж нэрлэх нь гол биш. Харин тэр өмчийн удирдлагыг орон нутаг хэрэгжүүлэх, ашиглах, өмчийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрхийг орон нутагт хэр хэрэгжүүлж байгаагаар тодорхойлогдоно оо. Энэ эрхгүй болбол тэр

аймаг орон нутгийн төвлөрлийг сааруулах эрх хэмжээ бүрэн төгс эргэж чадахгүй. Ийм учраас энэ асуудлыг тэр өмчийн эрхийн асуудалд өмчийн, орон нутгийн өмчийн харилцаан дээр тодруулж суулгах шаардлагатай. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаатай нийцэх ёстой.

3 дугаарт нь энэ багийн хурлыг сонгох зарчим бол тэр 3 өрх тутмаас 1-ээс доошгүй гэдэг болохоор 1 өрхөөс хэдэн ч хүн бүртгүүлдэг. Одоо улсын бүртгэл дээр 1 айл дээр баахан хүн бүртгүүлчихсэн байна энэ тэр гэдэг хэл ам маргааны үндэс болно. Үндсэн хуулийн үзэл санаатай нийцэхгүй ээ. 1 айлаас 5, энэ улсын бүртгэл дээр сонгууль болгоноор яригдаад байдаг энэ асуудал чинь энэнтэй холбогддог юм байна лээ.

Ийм учраас энэ орон нутгийн өөрөө удирдах ёсны хувьд ч гэсэн тэр, нийтийн хурлын тэр босгыг ийм байдлаар тогтоох нь бол Үндсэн хуулийн үзэл санаатай нийцэхгүй ээ. Үүнтэй нийцүүлэх шаардлагатай.

Ийм учраас энэ саяын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Үндсэн хуулийн үзэл санаатай нийцүүлж гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна аа.

Энэ асуудлуудыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд гүйцээн боловсруулж бусадтай уялдуулах шаардлагатай.

Ийм учраас нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж үзэж санал хураалт явуулъя аа.

Ингээд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийг анхны хэлэлцүүлэгт Байнгын хороонд буцаах горимын саналаар санал хураалт явуулна аа.

За Их хуралдай танхим. Санал хураалт явуулъя.

Д.Тогтохсүрэн: 15 гишүүнээс 8 гишүүн дэмжсэн байна.

Г.Занданшатар: Туваан гишүүн дэмжсэн, Доржанд гишүүн дэмжсэн.

Д.Тогтохсүрэн: 9 гишүүн байна.

Г.Занданшатар: Пүүжээ гараа өргөсөн юм.

Д.Тогтохсүрэн: 11 гишүүн.

Г.Занданшатар: За 15-аас 11 гишүүн байна аа.

Их эзэн Чингис хааны танхимаас.

С.Амарсайхан: Их эзэн Чингис хааны танхимд 15 гишүүнээс 12 гишүүн дэмжиж саналаа өгсөн байна аа.

Г.Занданшатар: Жанжин Д.Сүхбаатарын танхимаас.

Х.Булгантуяа: Сүхбаатар танхимаас 11 гишүүнээс 9 гишүүн дэмжлээ.

Г.Занданшатар: Үндсэн хуулийн танхимаас.

Ж.Сүхбаатар: Үндсэн хуулийн 7 гишүүнээс 3 нь дэмжлээ.

Г.Занданшатар: Их засаг танхимаас.

Т.Энхтүвшин: Санал хураалтад 8 гишүүн оролцсоноос 8 гишүүн дэмжсэн байна аа.

Г.Занданшатар: 8-аас 8 гэсэн үү?

Санал хураалтад 56 гишүүн оролцож, 43 гишүүн дэмжиж 76,8 хувийн саналаар энэ горимын санал дэмжигдлээ.

Анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж Байнгын хороонд буцааж байна аа.

За ингээд өнөөдрийн чуулганаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

Одоо даргын дэргэдэх зөвлөл хуралдана аа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ